



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР



Европын Холбоо  
санхүүжүүлэв



Food and Agriculture  
Organization of the  
United Nations

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын  
Хөдөлмөрийн  
Байгууллага



2023 ОНЫ УЛИРАЛ I

## ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ

“МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ  
УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН  
ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

# УЛИРЛЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Хэрэгжих хугацаа: 2020 – 2024

Төслийн төсөв: 7,400,000 Евро

### Зорилго, зорилт:

Төсөл нь Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, зохистой хөдөлмөрийг дэмжих ерөнхий зорилгын хүрээнд дараах зорилтууд дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:



БОДЛОГЫГ САЙЖРУУЛАХ ЗАМААР  
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ЧАДАВХ,  
БОЛОМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН САЛБАРТ ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН, ҮР НӨЛӨӨТЭЙ,  
НОТОЛГООНД СУУРИЛСАН БОДЛОГО, ТӨСВИЙН УЯЛДААГ ХАНГАХ  
ТӨСӨВ, САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ

### Төслийн үр шимийг хүртэгсэд:

Залуучууд

Тариаланчид,  
малчид

Алслагдсан орон  
нутгийн залуучууд,  
зорилтот бүлгүүд

Хөгжлийн  
бэрхшээлтэй  
иргэд

Охид,  
эмэгтэйчүүд

Албан бус эдийн засагт  
ажиллаж буй эрэгтэй,  
эмэгтэй хүмүүс

Ажилгүй, бүрэн бус  
хөдөлмөр эрхэлдэг  
хүмүүс, ажил хайгчид

ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

## А Бүрэлдэхүүн хэсэг А: БОДЛОГО, ТӨСВИЙН УЯЛДААГ ХАНГАХ

### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

#### ■ Үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт:

Үр дүнд суурилсан төлөвлөлтийг сайжруулах чиглэлд Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ)-тай хамтран 2024 оны Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөг (УЖХТ) үр дүнд суурилсан аргачлалаар хийхэд төслөөс дараах чиглэлээр мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Үүнд:

- “Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах” журамд өөрчлөлт оруулах
- Үр дүнд суурилсан арга зүйгээр УЖХТ-г боловсруулах аргачлал, загвар маягт боловсруулах
- ЭЗХЯ-тай хамтран 2023 оны 1 дүгээр сарын 5, 6-ны өдрүүдэд бүх яамд, агентлагуудын 150 гаруй албан хаагчийг хамруулсан сургалтыг зохион байгуулахад хамтран ажилласан. ➔ [Мэдээ унших холбоос.](#)

А

### ХҮРЭХ ҮР ДҮН

- Төсвийн төлөвлөлтийг үр дүнгийн мэдээлэлд үндэслэн, стратегич байдлаар боловсруулах
- Үр дүнд суурилсан төсвийн танилцуулга
- Нотолгоонд суурилан төсөв боловсруулах
- ТХЗ-той уялдсан үр дүнд суурилсан төсөв боловсруулах чиглэлээр Сангийн яам (СЯ), салбарын яамдын чадавхыг бэхжүүлэх

Улсын хэмжээнд нийт 39 төсвийн ерөнхийлөн захирагч (ТЕЗ)-ийн 2024 оны төлөвлөгөөний төслийг үр дүнгийн 4 түвшинд (үндэсний, салбарын, ТЕЗ болон хөтөлбөрийн) тодорхойлон, түвшин бүрт харгалзах шалгуур үзүүлэлт болон түүний суурь, зорилтот түвшинг тодорхойлж, хүрэх үр дүнг хангахад чиглэсэн үндсэн үйл ажиллагаа болон хөтөлбөрийн жагсаалтыг шинэчлэх саналыг боловсруулахад ЭЗХЯ-тай хамтран ажиллалаа. Улмаар 3 дугаар сарын 28-ны өдөр салбарын яамдад гарсан үр дүнг, 3 дугаар сарын 31-ны өдөр Сангийн яаманд хөтөлбөрийн жагсаалтыг танилцуулсан. Уулзалтанд сангийн яамны 23, ЭЗХЯ-ны 15 төлөөлөл тус тус оролцон санал солилцлоо.

#### ■ Үр дүнд суурилсан төсөвлөлт:

Үр дүнд суурилсан төсөвлөлт (ҮДСТ)-ийн гарын авлага болон Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлага (ҮДСНУ)-ын удирдамжийг боловсруулж байна.

Төсөл нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)-аас гадна орон нутгийн түвшинд ҮДСТ-ийг туршин нэвтрүүлэх зорилгоор Дорноговь аймгийг сонгон хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. Аймаг, нийслэл, хотын Жилийн хөгжлийн төлөвлөгөө (ЖХТ) хийх аргачлалыг Дорноговь аймагт туршин сайжруулах ажлыг 4 дүгээр сард хийхээр төлөвлөж байна.

#### ■ Нотолгоонд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт:

Төсөл нь 2022 оны 2 дугаар сараас эхлэн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтийн тогтолцоонд шинжилгээ хийсэн бөгөөд судалгаанд Орхон, Дорноговь, Өвөрхангай аймаг, мөн хотын бүсээс Сонгинохайрхан дүүргийг сонгон ажилласан. Судалгаанаас гарсан үр дүнд үндэслэн СЯ болон ХНХЯ-тай хамтран хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн төсвийн зардлын ангиллыг шинэчлэн СЯ-ны төсвийн программд оруулсан.

2023 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн үр дүн, гарц, үйл ажиллагаа (үйлчилгээ, хөтөлбөр, арга хэмжээ)-ны шалгуур үзүүлэлтүүдийг ХНХЯ-тай хамтран боловсруулж Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр батлуулахад төслөөс дэмжиж оролцлоо. Мөн профайлинг (хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ) ба хувийн төлөвлөгөө боловсруулах үйлчилгээний зардал, өртгийн шинэчилсэн тооцооллыг хийсэн ба аймаг, дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар (ХХҮГ) хэлтсээр төсвийг хуваарилан, төсвийн хуваарьт оруулсан. Орхон, Дорноговь, Өвөрхангай аймгийн ХХҮГ-ын Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтнүүд, сумдын хөдөлмөр, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн албан тушаалын чиг үүрэгт дүн шинжилгээ хийж төрийн байгууллагуудын ажилтнуудын албан тушаалын тодорхойлолт, чиг үүрэгт дүн шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал, зааврын төслийг боловсруулан ХНХЯ-нд хүргүүлсэн.



"ХЭДС-ийн 2023 оны төсвийг үр дүнд суурилсан төлөвлөсөн нь" уулзалт хэлэлцүүлэг

Хөдөлмөр эрхлэлт, соёл, биеийн тамирын салбарт зарлагын шинжилгээ хийгдэж байна. ХХААХҮ-н салбарт хийгдсэн зарлагын шинжилгээг салбар яамны мэргэжилтнүүдэд танилцуулах уулзалтыг 2 дугаар сарын 27-нд зохион байгуулсан. > [Мэдээ унших холбоос](#)

## А

### Бүрэлдэхүүн хэсэг

#### ■ Үр дүнд суурилсан тайлагналт:

Үр дүнд суурилсан төсвийн гүйцэтгэлийн тайлангийн маягтуудыг ТЕЗ-ын хүрэх үр дүнгийн гүйцэтгэлийн тайлангийн маягт, Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэлийн тайлангийн маягт болон Хөтөлбөрийн бүтээгдэхүүн, арга хэмжээний гүйцэтгэлийн тайлангийн маягт) бэлтгэх гарын авлагыг туршин сайжруулах ажлыг хийж гүйцэтгэж байна.

СЯ-ны төрийн сантай хамтран ХНХЯ, ХХААХҮЯ-ны дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан хөтөлбөр, Хавсралт 1-ийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн харьцуулсан шинжилгээ хийж, ХНХЯ болон ХХААХҮЯ-ны Төсвийн тухай хуулийн 2021 оны Хавсралт 1-ийн гүйцэтгэл болон Улсын жилийн

хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг харьцуулж, зөрүүг тодорхойлсон. Үр дүнгийн гүйцэтгэлийн зөрүүний шалтгааныг тодорхойлох үүднээс бодлогын баримт бичгүүдийн төлөвлөлтөөс эхлэн шинжилгээ хийн холбогдох тайланг бэлтгээд байна.

Улс, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 56, төвлөрүүлэн захирагчийн 490, шууд захирагчийн 7,032 төсөвт байгууллага болон төсөл, сангийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн Хавсралт 1 буюу хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайланг бэлтгэж байна.

## ХҮРЭХ ҮР ДҮН

- Төсвийн хяналтад УИХ-ын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх
- Төсвийн шинжилгээ, гүйцэтгэлд хяналт тавихад Иргэний, нийгмийн байгууллага (ИНБ)-ын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх
- Гүйцэтгэлийн аудитыг бэхжүүлж ил тод байдлыг хангах

## В

### Бүрэлдэхүүн хэсэг

## Бүрэлдэхүүн хэсэг В: ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

#### ■ УИХ-ын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх:

Олон улсын (АНУ, Гүрж, Канад, Шинэ Зеланд, Солонгос) сайн туршлагуудыг харьцуулан судалж, 'Төсвийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх' чиглэлд судалгааны тайланг бэлтгэж цаашид анхаарах дүгнэлт, зөвлөмжийг төсвийн байнгын хороонд хүргүүлсэн. Төслийн багаас төсвийн хэрэгжилтэд хяналт тавих сонсгол, олон нийтийн хэлэлцүүлэгт бэлтгэх, зохион байгуулахад зориулсан нарийвчилсан замын зураг, гарын авлагын төслийг бэлтгэж эхлээд байна.

Төсвийн байнгын хорооноос боловсруулсан Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон бусад дагалдах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлал, хэрэгцээ шаардлагын тандан судалгаа, хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа, хуулийн төслийн зардлын тооцоотой танилцаж, Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд үр дүнд суурилсан төсөвлөлтийг нэвтрүүлэх хүрээнд санал боловсруулж төсвийн байнгын хороонд мөн хүргүүлээд байна.

#### ■ ИНБ-ын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх:

2022 онд нийт 10 ИНБ-уудад дэмжлэг үзүүлэн төсвийг хянасан тайланг бэлтгүүлсэн. Тайлангуудын үр дүнг нэгтгэсэн хураангуй тайланг 2023 оны 2 дугаар сард гаргасан. (➤ [Тайланг татах холбоос](#)). Улмаар ИНБ-уудын оролцоо, гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх чиглэлд төслийн багаас хийгдсэн ажлыг олон нийтэд түгээх зорилгоор 4 видео контентыг гаргахаар ажиллаж байна.

#### ■ Үндэсний Аудитын Газар:

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Байгууллагын Хөгжлийн Санаачилгаас боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын гарын авлагыг орчуулан, хэрэглээнд нэвтрүүлэх зорилгоор Үндэсний аудитын газрын Төрийн стандартын хороогоор батлуулахад УАГ-т дэмжлэг үзүүлэн ажилласан.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийхэд арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан.

Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо үр нөлөөг үнэлэх гүйцэтгэлийн аудитад арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

### УЛИРЛЫН ХУРААНГУЙ

## В

C

## Бүрэлдэхүүн хэсэг С: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

#### ■ Хөдөлмөр эрхлэлт

2023 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа (хөтөлбөр)-г үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт, төсөвлөлтийн зарчимд үндэслэн боловсруулахад, мөн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн тогтоолоор батлуулахад ХНХЯ-нд төслийн зүгээс дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Энэ ажлын үр дүнд 2023 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлт (ХЭ)-ийг дэмжих үйл ажиллагаа (хөтөлбөр)-г иргэн төвтэй, хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээнд суурилан хэрэгжүүлэх төдийгүй хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдсан иргэнийг кейс байдлаар тасралтгүй дэмжлэг үзүүлж ажиллах юм. Үйлчлүүлэгч-суурьтай ХЭ-ийн үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбогдуулан аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн (ХХҮГ/Х) бүтцийг шинэ зохион байгуулалтаар өөрчилсөн ба энэ бүтцийн өөрчлөлтийн хүрээнд ХЭ-ийн асуудал хариуцсан мэргэжилтний ажлын чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, ХХҮЕГ-т хүлээлгэн өгөөд байна.

Төслийн зүгээс 2022-2023 онд профайлинг үйлчилгээ авсан ажилхайгч, ажилгүй иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.



Оёдолчны чадамжийн гэрчилгээ авсан оролцогчид

#### ■ Хөдөлмөр эрхлэлтийн үр чадварыг дэмжих ба Мэргэжлийн боловсрол сургалт

“Энтерпренёршип ба бизнес эрхлэх үр чадвар” сургалтын хөтөлбөрийг боловсруулан Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын ерөнхий газраар магадлуулсан. Хөтөлбөрийн танилцуулгыг Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын удирдлагуудад 2023 оны 2 дугаар сарын 7-ны өдөр

Энэхүү сургалтад Төв аймгийн Баянчандмань сум болон Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн ажил хайгч, ажилгүй 59 иргэн хамрагдаж, бүгд II түвшний чадамжийн гэрчилгээ авсан. Энэ ажлын хүрээнд 10 мэргэжлээр сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан бөгөөд туршилтын явцад гарсан бэрхшээл, хүрсэн үр дүнг ХНХЯ-нд танилцуулан цаашид зохион байгуулахад анхаарах асуудлыг хуваалцсан. > [Мэдээ унших холбоос](#)

Мөн бодлого, төсөв, санхүүжилтийн механизмын уялдааг хангах замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд Хуримтлалын нэгдсэн сангийн тогтолцоог бий болгох чиглэлд ХНХЯ-тай хамтын ажиллагаа эхлүүлэхээр эрчимтэй ажиллаж байна.

> [Мэдээ унших холбоос](#)

### ХҮРЭХ ҮР ДҮН

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөрүүдийг сайжруулах, харилцан уялдаатай болгох
- Инновац, гарааны бизнес, бизнес инкубаци, бизнес эрхлэхэд ээлтэй экосистемийг бэхжүүлэх
- Цалинтай болон хувиараа хөдөлмөр эрхлэх чадавч, үр чадварыг нэмэгдүүлэх
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр үр дүнтэй сургамж цуглуулах, улмаар бодлогод тусгах зорилгоор туршилтын төслүүд хэрэгжүүлэх

C





Төсөл нь хөдөлмөр эрхлэлтийн чиглэлд хэрэгжиж байгаа төсөл/хөтөлбөрийн мэдээллийг нэгтгэн харах цахим платформыг 2022 онд хөгжүүлсэн ба цаашдын тогтвортой байдлыг хангах үүднээс төслүүдийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг үүсгэх,

### ■ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын төслүүд

Ингэний сүүний нэмүү өртгийн сүлжээг төр-хувийн хэвшлийн түншлэлийн загварт суурилан хөгжүүлэх, бэхжүүлэх чиглэлийн хүрээнд Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутаг дэвсгэрт хагас эрчимжсэн тэмээний сүүний ферм байгуулах талаар оролцогч талуудын уулзалтыг 1 сарын 15-аас 20-ны өдрүүдэд зохион байгуулж, улмаар "Solid Partners Group" ХХК фермийн бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлээд байна. Төслийн хүрээнд тэмээний сүү саах тоног төхөөрөмжийн дэмжлэгийг үзүүлэхээр худалдан авалтыг үйл ажиллагааг эхлүүлсэн байгаа бөгөөд тухайн фермд сүүгээ өгөх тэмээний эрүүл мэндийн үзлэг, мал эмнэлгийн үйлчилгээг үзүүлэх, түүнчлэн тэдгээр тэмээний идэж буй тэжээл сүү, сүүний гарцад хэрхэн нөлөөлж буйг судлах чиглэлээр үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ.

ДНБ-ний 13%, нийт ажиллах хүчний 26%-ийг бүрдүүлж буй Хөдөө аж ахуйн салбарт залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдний инновац шингээсэн бүтээгдэхүүн, шийдлийг дэмжих зорилготой шинэлэг гарааны бизнесүүдийг шалгаруулах

ашиглах, тайлагнах түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалтыг хангах журмын төслийг боловсруулан ХНХЯ-д хүргүүлсэн. (➤ [платформ холбоос](#))

"Agripreneurship Challenge" тэмцээнийг амжилттай зохионбайгууллаа. Тус тэмцээнд 21 аймаг, нийслэлээс нийт 100 гаруй аж ахуй нэгж бүртгүүлснээс эцсийн шатанд 8 компани шалгарч, 2023 оны 3 дугаар сарын 7-ны өдөр "Demo Day" арга хэмжээний үеэр компаниуд өөрсдийн питч танилцуулгаа хийж, дараах гурван инновац шингээсэн компанийн бүтээгдэхүүн шилдгээр шалгарав. (➤ [Хураангуй видео бичлэг](#)). Үүнд:

- ◆ **I байрыг** Эйрий Фелт ХХК-ийн "Агаарын хонин ноосон шүүлтүүр"
- ◆ **II байрыг** Мэжик би фүүдс ХХК-ийн зөгийн хандны өвдөлт намдаах, үрэвсэл дарах, эд эс сэргээх үйлчилгээтэй тосон түрхлэг
- ◆ **III байрыг** Спек материалс ХХК-ийн аргалын цаас зэрэг эзлэв.

Шилдгээр шалгарсан 3 компани нийт 50 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын шагналын эзэд болоод зогсохгүй төслийн зүгээс тэдний шинэлэг бүтээгдэхүүнийг Монголд төдийгүй олон улсын зах зээлд гаргахад үргэлжлүүлэн хамтран ажиллаж, дэмжинэ.



D

Бүрэлдэхүүн хэсэг

## Бүрэлдэхүүн хэсэг D: ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ

### ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- ХНХЯ-с олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Аж үйлдвэр худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай" 81 дүгээр конвенц, "Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай" 129 дүгээр конвенцод нэгдэн орох бэлтгэл ажлыг эхлүүлсэн. Энэ ажлын хүрээнд конвенцод нэгдэн ороход шаардлагатай баримт бичгийг боловсруулахад (хуулийн төслүүд, хуулийн танилцуулга боловсруулах гэх мэт) дэмжлэг үзүүлэх үндэсний зөвлөлтэй гэрээ байгуулан ажиллаж байна.
- Хөдөлмөрийн хууль тогтоомжийг олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээтэй нийцүүлэх ажлын хүрээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 2021-2025 оны үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2023-2025 онд ХНХЯ, ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллагаас хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, тодорхойлох, эрэмбэлэх, санал солилцох гурван талт уулзалтыг зохион байгууллаа. [➤ Мэдээ унших холбоос](#)
- Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг дэмжих суурь тогтолцооны тухай 187 дугаар конвенцод Монгол Улсыг нэгдэхэд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд хуулийн нийцлийн судалгааг ХНХЯ-тай хамтран эхлүүлэв. >

### ХҮРЭХ ҮР ДҮН

- Хууль эрх зүйн орчныг олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээтэй нийцүүлэх
- Хөдөлмөрийн хяналтын байгууллагын чадавхыг бэхжүүлэх замаар хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах

• Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд 2023 сарын аяныг ХНХЯ, ХАБЭМТ, МҮЭ, МАОЭНХ-той хамтран хэрэгжүүлж байна. Аяны хүрээнд ХАБЭМ-ийн "Эрүүл, аюулгүй ажил бол бидний суурь эрх" уриан доор фото челленж, постер, хоёр богино видео ([➤ видео холбоос](#)) зэргийг төслийн санхүүжилтээр боловсруулан олон нийтэд түгээн ажиллаж байна.

• 2023 оны 1-р сарын 1-с хөдөлмөрийн хяналтын чиг үүрэг МХЕГ-с ХНХЯ дээр шилжин ирсэнтэй холбогдуулан хөдөлмөрийн хяналтын бодлого, эрх зүйн орчин, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр ХНХЯ-д арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.



УЛИРЛЫН ХУРААНГУЙ



## ТӨСЛИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧДИЙН ТҮҮХЭЭС







➤ У.Даваадоржийн түүхтэй танилцах холбоос



➤ Б.Хоролцэцэгийн түүхтэй танилцах холбоос

## 2023 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРАЛД ХЭВЛЭН НИЙТЭЛСЭН ТАЙЛАН



### Төслийн холбоо барих хаяг

#### ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ

**”МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ**

Монгол Улс, Улаанбаатар 14201

Сүхбаатар дүүрэг, Нэгдсэн Үндэстний гудамж - 14

Нэгдсэн Үндэстний байр

Утас: **976-7772 0272**

